



БАЯНХОНГОР АЙМАГ  
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/60

Хөхбүрд

Газар зүйн нэрийн салбар зөвлөл  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1.1, Геодези, зураг зүйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.8.1, 5.8.4, 11 дүгээр зүйлийн 11.1, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 186 дугаар зарлиг, Улсын Их хурлын 2003 оны 42 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумын “Газар зүйн нэрийн салбар зөвлөл”-ийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Салбар зөвлөлийн дарга:Засаг даргын орлогч

Гишүүд:Байгаль орчны хяналтын Улсын байцаагч

Мал эмнэлэгийн тасгийн Улсын байцаагч

Хөдөө аж ахуйн тасгийн дарга

Санхүүгийн албаны дарга

Мандалхайрхан 1 дүгээр багийн Засаг дарга

Уранхайрхан 2 дугаар багийн Засаг дарга

Асгамба 3 дугаар багийн Засаг дарга

Мэргэн 4 дүгээр багийн Засаг дарга

Хэсгийн төлөөлөгч

Иргэдийн төлөөлөл

Жолооч

Нарийн бичгийн дарга:Газрын даамал

2.Газар зүйн нэрийн хээрийн тодруулалтыг сумын хэмжээнд хийх ажлыг зохион байгуулах, “Газар зүйн мэдээллийн сан” бүрдүүлэх, шинээр нэр өгөх, өөрчлөх, газар зүйн нэрийн саналыг хэлэлцэн Газар зүйн нэрийн зөвлөлд хүргүүлэхийг салбар зөвлөлийн даргад үүрэг болгосугай.

642501037

D/2025/Засаг даргын захирамж А4.дс

3.Салбар зөвлөлийг ажиллах нөхцөл боломжоор хангаж, шаардлагатай төсөв санхүүгийн дэмжлэг үзүүлж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргад даалгасугай.

ДАРГА  Д.БЯМБАДОРЖ



